



Хялбаршуулсан хэлбэрээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж



Улаанбаатар хот
2024 он



Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр Монголбанкны дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн мэдээллийн албаны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг <https://fiu.mongolbank.mn/mn/> цахим хуудаснаас авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
ХУРААНГУЙ	5
УДИРТГАЛ.....	6
ХЯЛБАРШУУЛСАН ХЭЛБЭРЭЭР ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ..	7
1. Эрсдэлийг үнэлэх	10
2. Харилцагчийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулах	13
Бодит жишээ	13
3. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны төрлийг сонгох	13
4. Тогтмол хянах.....	15
Бодит жишээ	16
5. Баримт материалыг хадгалах	17
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	18

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНДМУТБ	Ази, Номхон далайн Мөнгө угаахтай тэмцэх бүлэг
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МҮЭ	Мэдээлэх үүрэгтэй этгээд
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
УТНБЭ	Улс төрд нөлөө бүхий этгээд
ҮОХЗДСТ	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ХТМ	Харилцагчийг таньж мэдэх

ХУРААНГУЙ

МУТС, ҮОХЗДСТ чиглэлийн олон улсын стандартыг тогтоогч байгууллага болох Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага “ФАТФ”-аас эрсдэлд суурилсан арга хэмжээний хүрээнд харилцагчийн эрсдэлийн түвшингээс хамааран ХТМ өөр өөр арга хэмжээг тодорхойлсон. Үүнтэй холбогдуулан бага эрсдэлтэй харилцагчид хялбаршуулсан арга хэмжээ, өндөр эрсдэлтэй харилцагчид нарийвчилсан арга хэмжээг авах талаар зааж өгсөн байдаг.

Тиймээс хялбаршуулсан хэлбэрээр ХТМ нь эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэхэд тусалж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмээн үздэг.

Мөн МУТСТ тухай хуульд заасны дагуу МУТС эрсдэлээс хамгаалах хяналтын тогтолцоог өөрийн үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээнд уялдуулан нэвтрүүлэх шаардлагатай байдаг. Энэ үүргийн биелэлтийг хангуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү зөвлөмжийг СМА-наас боловсруулан гаргасан бөгөөд цаашид зөвлөмжийг сайжруулах, агуулгыг дэлгэрүүлэхтэй холбоотой санал хүсэлтийг хүлээн авч, шаардлагатай бол энэхүү зөвлөмжид тусгах ажиллагааг зохион байгуулахад нээлттэй болно.

УДИРТГАЛ

Зорилго: МУТСТ тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт эрсдэлийн үнэлгээнд үндэслэн ХТМ үйл ажиллагааг хялбаршуулсан байдлаар хийж болно гэж заасны дагуу энэхүү зөвлөмжийг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх, хялбаршуулсан хэлбэрээр ХТМ үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулав.

Зөвлөмжийг хэн ашиглах вэ?

МУТСТ тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан МҮЭ ашиглана. Үүнд:

- 4.1.1.банк;
- 4.1.2.банк бус санхүүгийн байгууллага;
- 4.1.3.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
- 4.1.4.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
- 4.1.5.үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- 4.1.6.хадгаламж, зээлийн хоршоо;
- 4.1.7.үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
- 4.1.8.20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/-ийн бэлэн мөнгөний гүйлгээнд оролцсон бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
- 4.1.9.нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч;
- 4.1.10.виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч;
- 4.1.11.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд.

ХЯЛБАРШУУЛСАН ХЭЛБЭРЭЭР ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХТМ гэдэг нь харилцагчийг тодорхойлох мэдээллийг харилцагчаас гаргуулж авах бөгөөд хэнийг төлөөлж байгаа, ямар үйл ажиллагаа явуулдаг, ямар зорилгоор харилцаж байгаа зэрэг мэдээллийг тодруулах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглан мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь харилцагчийн болон түүний төлөөлж байгаа этгээдийн эцсийн өмчлөгч, харилцагчийн бизнесийн үр шим хүртэгч этгээд, удирдах эрх бүхий этгээдийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулах зорилготой юм.

МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд ¹ ХТМ шаардлагыг зохистой хэрэгжүүлэх зорилгоор харилцагчийг тодорхойлох, харилцагчийн мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагаанд заасан шаардлагын дагуу:

- ❖ Харилцагч нь хувь хүн;
- ❖ Харилцагч нь хуулийн этгээд;
- ❖ Харилцагч хуулийн этгээдийг төлөөлж байгаа зэргээс хамааран ялгаатай байдлаар хийнэ.

ХТМ үйл ажиллагааг доорх тохиолдолд авч хэрэгжүүлэх үүрэгтэй:

- Бизнесийн харилцаа үүсгэхийн өмнө;
- Дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээд тохиолдлын чанартайгаар 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө;
- Харилцагчийн 24 цагийн дотор хийсэн, хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/, түүнээс дээш үнийн дүнтэй бол;
- Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд;
- Тухайн харилцагч, тухайн гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд.

¹ https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/20230125_A26.pdf

ХТМ үйл ажиллагааг тогтмол явуулах нь дараах ач холбогдолтой.

Комплаенс

- Холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх, дагаж мөрдөөгүйгээс үүсэх торгуулиас сэргийлнэ.

Нэр хүнд

- Нэр хүндээ хадгалах нь аливаа санхүүгийн байгууллага, бизнесийн хувьд чухал юм.

Аюулгүй байдал

- Харилцагчийн мэдээллийг шинэчлэх нь байгууллагын аюулгүй байдлын ерөнхий байдлыг бэхжүүлдэг. Хувийн мэдээллийг хулгайлах болон кибер аюулгүй байдлын бусад эрсдэлийг бууруулдаг.

Эрсдэлийг бууруулах

- Харилцагчийн мэдээллийг тогтмол хянаснаар байгууллагууд өөрсдийн харилцагчтай холбоотой аливаа эрсдэлийг тодорхойлж шийдвэрлэх боломжтой.

МУТСТ тухай хуулийн² 5.2 дахь хэсэгт заасны дагуу ХТМ-ийн тулд МҮЭ дараах арга хэмжээг авна:

1. Харилцагч нь **иргэн** бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;
2. Харилцагч нь **хуулийн этгээд** бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах;
3. Эцсийн өмчлөгчийн нэрийн өмнөөс данс нээж, гүйлгээ хийж байгаа эсэхийг мэдэх, ойлгох зорилгоор тухайн бизнесийн харилцааны зорилго, гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээллийг тодруулах;
4. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийн талаар болон харилцагчийн өмчлөл, хяналт, зохион байгуулалтын бүтцийг таньж мэдэхтэй холбоотой боломжит бүх арга хэмжээг авах;

² <https://legalinfo.mn/mn/detail/9242>

5. Харилцагч нь **хуулийн этгээд, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч бол** түүний нэрийн өмнөөс харилцах этгээд нь тийм эрхтэй эсэхийг нягталж уг этгээдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг тодорхойлж, баримт бичигтэй нь тулгаж шалгах;
6. Банк, санхүүгийн байгууллагын хоорондын шилжүүлэг хийгч, хүлээн авагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, харилцах утасны дугаар, дансны дугаарыг авах.

Хялбаршуулсан хэлбэрээр ХТМ нь ХТМ бүх үйл ажиллагаанаас чөлөөлөх биш бөгөөд бизнесийн харилцаа тогтоох эсвэл баталгаажуулахад авах суурь, хамгийн бага арга хэмжээ юм. Хялбаршуулсан ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлснээр өндөр эрсдэлтэй харилцагчдад илүү анхаарал хандуулах, комплаенсын нөөцөө үр ашигтай хуваарилах боломжийг олгож, нийт зардлыг бууруулах ач холбогдолтой.

ХТМ хялбаршуулсан үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа орж болно:

- ❖ Харилцагчийг тодорхойлох мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэх давтамжийг багасгах;
- ❖ Гүйлгээнд байнгын хяналт тавих болон гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах түвшинг бууруулах;

Хялбаршуулсан байдлаар ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дор хаяж дараах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

- Илэрсэн эмзэг байдлын нарийвчилсан мэдээлэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээг багтаасан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэлийн үнэлгээг хийж, баримтжуулах;
- Эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчлэх;
- Хялбаршуулсан арга хэмжээний талаар хэрэгжүүлэх бодлого, журмыг баримтжуулах.

Харин дараах тохиолдолд хялбаршуулсан хэлбэрээр ХТМ үйл ажиллагаа явуулахгүй.


- ☒ Харилцагч, эсхүл гүйлгээг МУТС-тэй холбоотой гэж сэжиглэсэн;
- ☒ МҮЭ, хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага, СМА-наас өндөр эрсдэлтэй гэж үзсэн бизнес, улс оронтой холбоотой харилцагчид байвал;
- ☒ УТНБЭ;
- ☒ МУТСТ үүрэг бүхий олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд;

- ☒ МУТСТ үндэсний эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээд.

Хялбаршуулсан хэлбэрээр ХТМ үйл ажиллагааны алхмууд:

1. Эрсдэлийг үнэлэх

МҮЭ нь МУТСТ үйл ажиллагааг **эрсдэлд суурилсан хэлбэрээр** хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжүүлэхдээ дараах эрсдэлийг харгалзан үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцүүлэн бодитойгоор үнэлнэ.



Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэл: МҮЭ нь хүн, хуулийн этгээдэд аливаа үйлчилгээг үзүүлэхээсээ өмнө өөрийн харилцагч, түүний эцсийн өмчлөгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй эсэхийг үнэлэх нь зүйтэй. Харилцагчийн эрсдэл гэдэг нь харилцагчаас үүсэх МУТС ерөнхий эрсдэл юм. Харилцагчаас хамаарч үүсэх эрсдэлийг тодорхойлсноор тухайн бизнестэй холбоотой этгээдүүдийг үнэлэх цар хүрээг тодорхойлоход тусалдаг. Харилцагч байгууллагын нарийн төвөгтэй зохион байгуулалтын бүтэц болон мэдээллийг хэт нууцлах бодлого зэрэг нь МУТС-тэй холбоотой эрсдэлийг нэмэгдүүлж, тухайн ХТМ нарийвчилсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх үндэслэл болж болно.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл: Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарах эрсдэл гэдэг нь тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг МУТС зорилгоор ашиглах боломжтой эмзэг байдлын илэрхийлэл юм. МҮЭ нь хүн, хуулийн этгээдэд аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохын өмнө МУТС үйл ажиллагаанд ашиглагдах эрсдэлтэй эсэхийг үнэлэх хэрэгтэй бөгөөд МУТС эрсдэлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээнд илүү өргөн хүрээний хяналт тавих шаардлагатай.

Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл: Газар зүйн байршлаас хамаарах эрсдэл гэдэг нь хүн, хуулийн этгээдтэй аливаа бизнесийн харилцаа тогтоохын өмнө тухайн харилцагчийн үүсгэн байгуулагдсан улс орныг судалж, МУТС эрсдэлтэй улс орноос гаралтай эсэхийг үнэлэх хэрэгтэй. Харилцагчийн гарал үүслийг илэрхийлэх улс орны авлига, гэмт хэргийн үзүүлэлт,

МУТС-тэй холбоотой хяналт шалгалтын тогтолцоо зэрэг хүчин зүйлсийг харгалзан газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэлийг тодорхойлно.

Улс орны газарзүйн эрсдэлийг тодорхойлохдоо төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжийг ашиглаж болно. Үүнд:

- ФАТФ-ын эрсдэл өндөртэй болон стратегийн ноцтой дутагдалтай улс орны жагсаалт³;
- ФАТФ-ын харилцан үнэлгээний тайлан⁴;
- Европын Холбооны мөнгө угаах⁵ болон татварын⁶ хар жагсаалт;
- Базелийн мөнгө угаахтай тэмцэх индекс⁷;
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн газар (UNODC)-ын тайлангууд;
- Транспэрэнси Интернэшнлээс гаргасан авлигын төсөөллийн индекс⁸;
- Итгэмжлэгдсэн, хараат бус хэвлэл мэдээллийн эх сурвалж;
- НҮБ-ын хориг арга хэмжээ.⁹

Харилцагчийн эрсдэлээс хамааран ХТМ үйл ажиллагааг 3 төрлөөр явуулах ба дээрх эрсдэлийн үнэлгээгээр харилцагч бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн тохиолдолд хялбаршуулсан байдлаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. ХТМ төрлүүд дараах байдалтай байна.



³ <https://www.fatf-gafi.org/en/countries/black-and-grey-lists.html>

⁴ <https://www.fatf-gafi.org/en/publications/Mutualevaluations/Assessment-ratings.html>

⁵ https://finance.ec.europa.eu/financial-crime/anti-money-laundering-and-counteracting-financing-terrorism-international-level_en

⁶ <https://www.consilium.europa.eu/en/policies/eu-list-of-non-cooperative-jurisdictions/#countries>

⁷ <https://index.baselgovernance.org/ranking>

⁸ <https://www.transparency.org/en/cpi/2023>

⁹ <https://www.un.org/securitycouncil/content/un-sc-consolidated-list>

Эрсдэлийн үнэлгээний үр дүнд бага эрсдэлтэй байж болох жишээнүүдийг дурдъя. Гэвч эдгээр нь бага эрсдэлтэй байж болох нэг л хүчин зүйл гэдгийг анхаарна уу.

Харилцагч нь:

- Тогтвортой, баталгаатай ажлын түүх, орлогын эх үүсвэртэй, цалинтай ажилтан;
- Тогтмол тэтгэврийн орлоготой ахмад настан;
- Харилцагч нь харилцан үнэлгээ болон явцын тайлан зэрэг баталгаатай эх үүсвэрээр МУТСТ тогтолцоо нь үр дүнтэй хэмээн тодорхойлогдсон улс орнуудаас ирсэн эсвэл эдгээр улсуудаар дамжуулан бизнесээ эрхэлдэг;
- Харилцагч нь авлига болон бусад гэмт хэргийн түвшин бага болох нь баталгаатай эх үүсвэрээр тодорхойлогдсон улс орноос ирсэн.

Гүйлгээ нь:

- Харилцагчийн дансанд тогтмол цалин, тэтгэврийн орлого орох;
- Ипотекийн зээл эсвэл зээлийн эргэн төлөлт;
- Харилцагчийн өөрийн нэг санхүүгийн байгууллага дахь данс хоорондын шилжүүлэг.

Дансны үйл ажиллагаа нь:

- Дансны үлдэгдэл болон гүйлгээний хэмжээ нь харилцагчийн мэдэгдэж буй санхүүгийн чадамжтай нийцдэг;
- Гүйлгээнд бэлэн мөнгөний хэрэглээ бага эсвэл огт байхгүй.

Харин зарим төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бага эрсдэлтэй байдаг бөгөөд эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглаж байгаа ихэнх харилцагчид хялбаршуулсан хэлбэрээр ХТМ үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Үүнд:

- Тодорхой гүйлгээний үнийн хязгаартай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ - нэг удаагийн болон байнгын гүйлгээний дээд хязгаарыг тогтоосон (хүүхдийн карт, оюутны карт, тэтгэврийн карт гэх мэт);
- Нарийн төвөгтэй онцлог байхгүй энгийн санхүүгийн бүтээгдэхүүн (жишээ нь, энгийн хадгаламж/харилцах данс, бага дүнтэй мөнгөн шилжүүлэг);
- Ердийн даатгалын үйлчилгээ, тэтгэврийн даатгалын үйлчилгээ;
- Богино хугацаат зээл.

2. Харилцагчийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулах

Эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн тохиолдолд ХТМ үйл ажиллагааг МУТСТ хуулийн 5.14 дэх хэсэгт заасан журмын дагуу тус хуулийн 5.2.1, 5.2.2-т заасан хүрээнд хялбаршуулсан байдлаар хийж болно.

- харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, иргэний үнэмлэхийн, эсхүл гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргуулж авах;
- харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газрын хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв баримт бичгийг шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг гаргуулж авах.

Бодит жишээ

Чайм банк

АНУ-ын Чайм банк нь эрсдэл багатай харилцагчдадаа цахимаар бүрэн автоматжуулсан данс нээх үйл явцыг ашигладаг. Ингэхдээ иргэний үнэмлэх, нүүр царайг таниулах, гуравдагч этгээдийн мэдээллийн эх сурвалжтай тулган шалгах замаар мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагаа явуулдаг байна.

Мөн тогтмол хяналт хийж, хориг арга хэмжээний жагсаалтыг автоматаар хянадаг байна.

Хондурас улс

Хондурас улсын Банк, Даатгалын Үндэсний хороо (CNBS) хэд хэдэн нөхцлийг хангасан энгийн хадгаламжийн данс нээх хялбаршуулсан үйл ажиллагааг боловсруулсан. Үүнд, энгийн хадгаламжийн дансыг зөвхөн тус улсын иргэн нээх, энэ нь зөвхөн тухайн улсын мөнгөн тэмдэгтийн данс байхыг заасан ба дансны дээд үлдэгдэл, сар бүр хуримтлуулсан дээд хэмжээ зэргийг тогтоож өгчээ.

3. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны төрлийг сонгох

Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн бага эрсдэлтэй харилцагчид хялбаршуулсан, өндөр эрсдэлтэй харилцагчид нарийвчилсан үйл ажиллагааг явуулна.

Хялбаршуулсан ХТМ болон нарийвчилсан ХТМ үйл ажиллагаа нь дараах ялгаатай байна.

	Хялбаршуулсан ХТМ	Нарийвчилсан ХТМ
Харилцагчийн төрөл	Бага эрсдэлтэй харилцагч	Өндөр эрсдэлтэй харилцагч
Гүйлгээнд байнгын хяналт тавих	Гүйлгээнд тавих байнгын хяналт болон гүйлгээтэй холбоотой нэмэлт мэдээлэл цуглуулах түвшинг бууруулж болно.	Харилцагчийн данс, гүйлгээнд тавих хяналт давтамжийг нэмэгдүүлж, өндөр хяналттай байна.
Харилцагчийн мэдээллийг шинэчлэх	Харилцагчийг тодорхойлох мэдээлэлд орсон өөрчлөлтийг шинэчлэх давтамжийг багасгаж болно.	Харилцагчийг бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлүүлнэ.
Бизнесийн харилцааны мөн чанар, зорилгыг ойлгох	Бизнесийн харилцааны зорилго, мөн чанарыг ойлгохын тулд тодорхой мэдээлэл цуглуулах, тодорхой арга хэмжээ авахгүй, харин хийсэн гүйлгээ, бизнесийн харилцааны төрлөөс зорилго, мөн чанарыг нь дүгнэж болно.	Харилцагчийн хөрөнгийн эх үүсвэр, бүтээгдэхүүн, үйлчилгээний зориулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, харилцагчийн бизнесийн үйл ажиллагаа, өмчлөлийн бүтэц, улс төрийн харилцааны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг авч болно.
УТНБЭ-г шалгах	УТНБЭ-д хялбаршуулсан ХТМ үйл ажиллагааг явуулахгүй.	УТНБЭ-гийн жагсаалт болон хориг арга хэмжээний жагсаалтыг шалгаж эрсдэлийн түвшинг үнэлнэ.
УТНБЭ-гийн гэр бүлийн гишүүд, нэгдмэл сонирхолтой хүмүүсийг тодорхойлох	-	УТНБЭ-гийн гэр бүлийн гишүүд, нэгдмэл сонирхолтой хүмүүсийг бизнесийн харилцаа үүсгэх

		үед болон харилцааны туршид тогтмол шалгана.
Орлого, хөрөнгийн эх үүсвэрийг шалгах	-	Орлого, хөрөнгийн эх үүсвэрийг тодруулан, гэмт хэргийн орлого биш гэдгийг баталгаажуулна.
Хориг арга хэмжээний жагсаалтад орсон эсэхийг шалгах	Харилцагчийг хориг арга хэмжээний жагсаалтад орсон эсэхийг шалгана.	
Тогтмол хяналт	Хяналтыг эрсдэлд суурилсан аргаар явуулах бөгөөд харилцагчийн эрсдэлийн түвшин дэх өөрчлөлтийг илрүүлнэ.	

4. Тогтмол хянах

Бизнесийн харилцааг үүсгэх үед бага эрсдэлтэй байх нь тухайн харилцагч бүх төрлийн харилцагчийг таньж мэдэх арга хэмжээ, ялангуяа гүйлгээнд тогтмол хяналт тавих үед бага эрсдэлтэй байна гэсэн үг биш юм.

Тогтмол хяналт гэдэгт хийгдэж буй гүйлгээ нь харилцагчийн талаарх МҮЭ-ийн мэдээлэл, данс/гүйлгээний зорилго, тэдгээрийн харилцаа, эрсдэлийн мэдээлэл, шаардлагатай бол эх сурвалжтай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд бизнесийн харилцааны явцад хийгдсэн гүйлгээг хянах, шалгах зэрэг орно. **Эрсдэл багатай харилцагчдын хувьд ч гэсэн гүйлгээ нь эрсдэл багатай байгаа эсэхийг шалгах шаардлагатай.**

Анх бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн ч цаашид өөрчлөгдсөн тохиолдолд харилцагчийн мэдээлэл эрсдэлийн зэрэглэлийг зохих ёсоор баталгаажуулах эсвэл дахин баталгаажуулах үйл ажиллагааг хийх шаардлагатай. Бага эрсдэлтэй харилцагчийн хувийн мэдээллийг шалгах эсвэл дахин баталгаажуулахыг шаардаж болох жишээг дурдъя. Гэвч үүгээр хязгаарлагдахгүй юм. Үүнд:

- ❖ Их хэмжээний гүйлгээ эсвэл олон дахин хийгдэж буй давтамжтай гүйлгээ хийх;
- ❖ Харилцагчийн гүйлгээ хийх сувагт мэдэгдэхүйц өөрчлөлт гарах;
- ❖ Харилцагчийн хүссэн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар өөрчлөгдөх;
- ❖ Огцом өөрчлөгдсөн их дүнтэй гүйлгээ хийсэн үед;
- ❖ Эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй гүйлгээ хийсэн үед;
- ❖ УТНБЭ-ийн нэр дээр хийсэн гүйлгээ хийсэн үед;

- ❖ МУТСТ чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан гүйлгээ хийсэн үед;
- ❖ Цахим шилжүүлэг, корреспондент харилцаанд үндэслэн хийгдэж байгаа гүйлгээ болон УТНБЭ гэдэг ангилалд хамаарах харилцагчийн эсхүл харилцагчийн эцсийн өмчлөгч нь УТНБЭ байгаа тохиолдолд;
- ❖ ВХҮҮ-ийн хувьд зохицуулалтгүй ВХҮҮ, бүртгэлгүй хэтэвч /unhosted wallet/, “хар жагсаалт”-д багтсан хэтэвч хооронд гүйлгээ хийсэн тохиолдолд.

Бодит жишээ

Нордеа банк

Нордеа банкны тогтмол хяналт тавих гүйлгээний хяналтын систем нь ердийн бус гүйлгээний хэв маяг, харилцагчийн зан үйлийн гэнэтийн өөрчлөлт зэрэг сэжигтэй үйлдлүүдийг илрүүлэхийн тулд дүрэм болон машинд суурилсан алгоритмуудыг ашиглан хялбаршуулдаг байна.

Систем нь дохиолол үүсгэж, сэжигтэй үйлдэл илэрвэл нэмэлт мэдээлэх авах, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зорилго, харилцагчийн бизнесийн үйл ажиллагааны талаар илүү нарийвчилсан мэдээлэл авах замаар ХТМ нарийвчилсан үйл ажиллагааг явуулдаг. Мөн банкны систем нь шинэ харилцагчдыг хориг арга хэмжээний жагсаалт, УТНБЭ-ийн жагсаалтаас автоматаар шалгадаг ба жагсаалтыг тогтмол шинэчилдэг байна.

Кени болон Египт улсын гар утасны мөнгөн гүйлгээ

Кени улсад бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг М-Песа нь бага дүнтэй гүйлгээнд хялбаршуулсан үйл ажиллагаа хэрэгжүүлдэг. Энэ үйлчилгээ нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хязгаарлалтыг тавьж, аливаа сэжигтэй үйлдлийг илрүүлэх автомат хяналттай бөгөөд шаардлагатай үед сайтар нягтлан шалгах арга хэмжээ авдаг.

Египт улс хялбаршуулсан байдлаар ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ гар утсаар шилжүүлэх мөнгөн дүнд дээд хязгаарыг тогтоосон бөгөөд (жишээ нь нэг удаагийн гүйлгээний дээд хэмжээ 286 евро, сарын гүйлгээний нийлбэр 2400 евро гэх мэт) тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд системд дохиолол үүсч, нэмэлт мэдээлэл авах байдлаар ажилладаг байна. Мөн харилцагчийг мэдээллийг цахим хэрэгслээр шинэчлэх, мэдээлэл цуглуулах давтамжийг багасгасан байна.

5. Баримт материалыг хадгалах

МҮЭ нь хялбаршуулсан хэлбэрээр ХТМ зорилгоор олж авсан аливаа мэдээлэл, баримт бичгийг бүртгэж, хадгалах ёстой. Бүртгэлийг холбогдох гүйлгээ хийгдсэн, бизнесийн харилцаа дуусгавар болсноос хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалах ба заасан мэдээлэл, баримт бичгийг заасан этгээд эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- FATF Guidance, Anti-Money Laundering and Terrorist Financing Measures and Financial Inclusion With a Supplement on Customer Due Diligence, 2017, <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/images/guidance/Updated-2017-FATF-2013-Guidance.pdf>
- FATF Methodology for assessing compliance with the FATF Recommendations and the effectiveness of AML/CFT systems, 2023, <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/methodology/FATF%20Methodology%2022%20Feb%202013.pdf.coredownload.pdf>
- FATF Recommendations, 2023, <https://www.fatf-gafi.org/content/dam/fatf-gafi/recommendations/FATF%20Recommendations%202012.pdf.coredownload.inline.pdf>
- How to Automate the Customer Due Diligence (CDD) Process, <https://www.middesk.com/blog/cdd-automation>
- Simplified Customer due diligence (SDD) guidance notes, Central Bank of Belize, 2023, https://www.centralbank.org.bz/docs/default-source/7.0-news-advisories/simplified-cdd-guidelines-november-2023.pdf?sfvrsn=78401700_3
- Simplified due diligence guidelines, Financial Services Authority Saint Vincent & The Grenadines, 2023, <https://web.svgfsa.com/wp-content/uploads/2023/01/Simplified-Due-Diligence-Guidelines.pdf>
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013, <https://www.legalinfo.mn/law/details/9242>
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, ФАТФ, Монголбанк, 2012-2019, <https://www.mongolbank.mn/documents/cma/20180531F2.pdf>
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлд суурилсан зарчмыг хэрэгжүүлэх удирдамж, Монголбанк, 2018, https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20180206_A32.pdf
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, Монголбанк, 2019, https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20160920_terrorism.pdf